

## САГСАЙ СУМЫН ЭМТӨВИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН



Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

### Аудитын тайлан

Баян-Өлгий аймгийн  
Аудитын газар

Тэргүүлэх аудитор  
М.Хуанган  
Утас:70422954  
Цахим хаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер:  
Х.Женисбек  
Утас: 70422930  
Цахим хаяг: jekbay01@yahoo.com

Аудитор: Х.Еркебулан  
Утас:70423073  
Цахим хаяг: akon\_erca@yahoo.com

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Хаяг:** Баян-Өлгий аймаг дахь  
Төрийн аудитын газар

**Байршил:** Өлгий сум, 5-р баг,  
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р  
давхар

**Цахим хуудас:** [www.bayan-  
olgii.gov.mn](http://www.bayan-olgii.gov.mn)

2018 оны 2 дугаар сар

## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим,  
хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланда хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

### **Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бурэн эрхийн хүрээнд Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 14-нээс 2 дугаар сарын 21-ний хооронд хийхээр төлөвлөн аймаг дах Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2018 оны 01-р сарын 23-ны өдөр Төрийн аудитын байгууллагад 01-р сарын 23-ны өдрийн №09-р албан бичгээр ирүүлсэн.

Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 2 дугаар сарын 19-нээс 2 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 25 -нд Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн удирдлагад гардуулна.

### **Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд

мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

### **Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

“Хүн амд эмнэлгийн анхан шатны болон суурь тусlamж үйлчилгээг хөнгөн шуурхай тэгш хүртээмжтэй хүргэж үйлчилнэ Зорилт Үйлчлүүлэгчид өрх гэр бүлийн эрхийг дээдэлсэн эрэлт хэрэгцээ хангасан тэгш хүртээмжтэй чанартай тусlamж үйлчилгээг үзүүлснээр хүн амын өвчлөл, эндэгдлийг тууштай бууруулж, амьдралын чанарыг дээшлүүлж эрүүл аж төрөх хэвшүүлэн төлөвшүүлнэ” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “Байгууллагын дарга тус байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Эрүүл мэндийн төвийн 2017 оны төсвийг аймгийн ТЕЗ-ийн тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймгийн төрийн сангаас санхүүжүүлэн, Сагсай сумын Төрийн сангаас олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

### **Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны санхүүгийн тайлан дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансадад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 10-ийг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын няглан бodoх бүртгэлийн бодлого, системтэй танилцахад эрүүл мэндийн төв нь санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх няглан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлаагүй боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, няглан бodoх бүртгэлийн бодлого, арга зүйг мөрдөж ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа программын үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Сагсай сумын Эрүүл мэндийн төв нь санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүүгийн тооцоолох төв ХХК-ны “Аколоус” программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

#### Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайландаа материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн албаны дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

#### Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Аймгийн ТЕЗ-ийн тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймаг, сумын төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Сагсай сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд 371.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 371.7 сая төгрөг зарцуулж, төсвөө 0.1 сая төгрөгөөр хэмнэж, төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзвэл цалинд 247.9 сая төгрөг, НДШ-д 27.3 сая төгрөг, тогтмол зардалд 21.2 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 25.3 сая төгрөг, норматив зардал 29.8 сая төгрөг, эд хогшил худалдан авах 3.3 сая төгрөг, томилолт зочны зардалд 0.6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил

үйлчилгээний зардалд 4.1 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 3.2 сая төгрөг, урсгал шилжүүлэг 9.0 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Тус Эрүүл мэндийн төвийн 2017 оны орон тоог 29-ээр баталсан ба гүйцэтгэлээр 38 орон тоо буюу 9 орон тоогоор хэтрүүлэн ажиллуулжээ.

### **Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж ажиллах зорилгоор [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) цахим хуудсанд 2017 оны мэдээлэлээ бүрэн байршуулжээ.

2017 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар Эрүүл мэндийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дахь заалтыг зөрчсөн тул 2017.12.21 №03/365 тоотын дагуу 362.8 сая төгрөгийн зөрчлийн биелэлтийг хангуулсан байна.

2017 оны 10-12 дугаар саруудын шилэн дансны мэдээллийг аудиторын зүгээс шалгаж Shilen dans-Sagsai EMToB файлаар баримтжуулж, тайлантай хамт ажлын талбарт хавсаргав.

### **Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 8 нарийвчилсан горим, сорилт гүйцэтгэв.

### **Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:**

Сагсай сумын Эрүүл мэндийн төв нь 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайландаа нөлөөлөхүйц хэмжээний орлого-санхүүжилт, мөнгөн хөрөнгө, бараа материал, цалин, НДШ-ийн зардал, ХАОАТ-ын зардал, эмийн зардал, түлш, тээвэр шатахууны зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Ажил гүйлгээ бага тул тус байгууллагын нийт орлого, нийт хөрөнгийг 100 хувь, нийт зардлын 80 хувийг хамруулж нарийвчилсан горим, сорилын аргаар шалгав.

### **Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг хэмжээний алдаа зөрчил илрээгүй. Материаллаг бус дараах асуудал байна.Үүнд:

1. Сагсай сумын ЭМТөвийн 2017 оны батлагдсан төсөвт орон тооны хязгаарыг 29 хүнээр тогтоосон ба гүйцэтгэлээр 38 орон тоо ажиллуулж, орон тоог 9 хүнээр хэтрүүлэн ажиллуулсан байна. Сувилагч 3, асрагч 3, угаагч 1, эмийн санч 1, гэрээт 1 нийтдээ 9 хүнээр илүү ажилуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.3, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.3 дах заалтууд болон УИХ-ын 2016 оны 69 дүгээр тогтоолын 3-ийн 1 дэх заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орон тооны хязгаарыг мөрдөж, зөрчлийг арилгахыг албан шаардлагаар үүрэг болгов.**

2. Батлагдсан орон тоог хэтрүүлэн ажилуулсаны улмаас цалинд 6.2 сая төгрөгийн, Нийгмийн даатгалын шимтгэлд 9.6 сая төгрөгийн, Хувь хүний орлогын албан татварт 2.1 сая төгрөгийн бүгд 17.9 сая төгрөгийн өглөгийг шинээр үүсгэсэн. Үрьд оноос шилжиж ирсэн 9.1 сая төгрөгийн өрийг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.3-т “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь: Тайлант оны эцэст үүссэн 27.0 сая төгрөгийн өглөгийг бүрэн барагдуулах арга хэмжээ авч ажиллахыг албан шаардлагаар үүрэг болгов.**

**Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Аудитын явцад залруулагдаагүй алдаа гараагүй болно.

**Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

**Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

**Санхүүгийн тайланда хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

**Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Аудитын гол асуудалд дурдсан алдаа зөрчлийг эс тооцвол Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ... хуудас хавсаргав.

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН  
Огноо:2018.02.28

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК  
Огноо:2018.02.28

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Х.ЕРКЕБУЛАН  
Огноо:2018.02.28